



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 9/458

Алтай хот

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 78.2.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам"-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 75 дугаар тогтоол, 2020 оны 30 дугаар тогтоолын дагуу 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдөр явагдах дахин дуудлагын худалдааг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Өмчийн төлөөлөгч: Т.Болд -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Хөтлөгч: Б.Балдорж -Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
Тэмдэглэл хөтлөгч: Б.Нансалмаа -Орон нутгийн өмчийн газрын архив, бичиг хэргийн ажилтан

2. Дахин дуудлагын худалдааг хууль, журмын дагуу ил тод, нээлттэй зохион байгуулж, дүнг 2020 оны 09 дүгээр сарын 05-ны дотор танилцуулахыг комисст даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (С.Байгальмаа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ



C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201001142